



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ -  
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

## БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2022 он)

*Төлөвлөгөө баталсан:*

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА

*Төсвийн шууд захирагч*

Б.ЦЭНГЭЛ

2022 оны 01 сарын 05-ны өдөр

*Төлөвлөгөө хянасан:*

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

*Нэгжийн дарга*

Н.ГАНБОЛД

2022 оны 01 сарын 05-ны өдөр

*Төлөвлөгөө боловсруулсан:*

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

*Албан хаагч*

Х.ЭНХЧИМЭГ

2022 оны 01 сарын 05-ны өдөр

БАТЛАВ  
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.ЦЭНГЭЛ

2022 оны .... сарын ....

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тухайн жилийн зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (улирал)	Хариуцах нэгж
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгон оновчтой бодлого, чиглэлийг хэрэгжүүлнэ.						
<b>Зорилт 1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	Батлагдсан төсвийн хүрээнд	- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хувиар;	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт - 70% хувь.	- Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт 85% хувь байна.	I-IV улирал	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (ТӨУЗХ); Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (ТӨБАХ); Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (ТӨХШХ); Хууль, эрх зүйн хэлтэс (ХЭЗХ).

<p><b>Арга хэмжээ 1.1. (1)</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох судалгаа, мэдээллийг боловсруулсан байх;</li> <li>- Боловсруулсан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төслийн тоо;</li> <li>- Батлагдсан төслийн тоо.</li> </ul>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.</p> <p>2021 онд бусад байгууллагаас ирүүлсэн 15 хуулийн төсөл, Засгийн газраас ирүүлсэн 3 тогтоол, 3 журмын төсөлд тус тус санал тусгуулахаар хүргүүлсэн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төсөлтэй холбоотой төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаарх судалгаа, мэдээллээр хангасан байна.</li> <li>- Холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төслийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.2. (2)</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, ажлын хэсэгт ажиллах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох судалгаа, үнэлгээ, тооцооллыг шинэчлэх, хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангасан байх;</li> <li>- Шат шатны хэлэлцүүлгийг бэлтгэх, хийх, түүнд оролцох;</li> <li>- Хэлэлцүүлэг, уулзалтуудаас гарсан саналыг боловсруулах, төсөлд тусгуулах;</li> <li>- Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, УИХ-д өргөн барихыг дэмжсэн байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн төслийг хүргүүлсэн;</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа хийгдсэн;</li> <li>- Ажлын хэсгийн уулзалтуудыг хийсэн;</li> <li>- Олон нийтийн хэлэлцүүлэг хийгдээгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн бүрдүүлбэр хангагдсан байна;</li> <li>- Олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.</li> <li>- Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.3. (3)</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны тоо, төрөл;</li> <li>- Санал боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлсэн байх;</li> <li>- Холбогдох хэлэлцүүлэг, уулзалтад оролцох;</li> <li>- Холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдсан байх.</li> </ul>	<p>Хуулийн төсөлд санал боловсруулж, ЗГХЭГ, ХЗДХЯ-нд тус тус хүргүүлж байсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай судалгаа, мэдээллээр холбогдох байгууллагыг хангасан байна;</li> <li>- Холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангасан байна.</li> </ul>	<p>I-II улирал</p>	<p>ХЭЗХ ТӨУЗХ</p>

<p><b>Арга хэмжээ 1.4. (4)</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд боловсруулах журам, заавар, дүрмийн төсөл боловсруулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох дүрэм, журмын төсөл нь хуульд нийцсэн, уялдаа холбоог хангасан байх;</li> <li>- Судалгаа хийгдсэн байх;</li> <li>- Оролцогч, хэрэглэгчийн саналыг авч тусгасан байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд журам батлахтай холбоотой 7 заалт байна.</li> <li>- Зарим дүрэм, журам батлах эрх үүрэг өнөөгийн хууль тогтоомжид тодорхой тусгагдаагүй байсан;</li> <li>- Хуулийн шинэчлэл хийгдсэн тохиолдолд 6&lt; журам, дүрмийг шинэчлэн боловсруулах, батлах шаардлага бий;</li> <li>- ТӨБЗГ-ын тогтоолоор батлагдсан 4 журам, 6 захиргааны акт мөрдөгдөж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуульд нийцүүлэн дараах журмыг боловсруулсан байна: "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-д нэмэлт, өөрчөлт оруулах тухай төсөл, "Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий гэрээг байгуулах, дүгнэх журам, заавар, аргачлал";</li> <li>- Оновчтой санал, зөвлөмжийг тусгасан байна;</li> <li>- Зарим дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлсэн байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.5. (5)</b></p> <p>Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл болон хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох судалгааны тоо;</li> <li>- Хувьчлах хуулийн этгээдийн тоо;</li> <li>- Хувьчлах эд хөрөнгийн тоо;</li> <li>- Төслийг холбогдох байгууллагад хүргүүлсэн эсэх;</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомж, бодлого, чиглэлд нийцсэн байх.</li> </ul>	<p>Засгийн газраас 2018 онд өргөн УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төслийг 2019 онд эгүүлэн татсан.</p> <p>УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгох асуудал тусгагдсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна;</li> <li>- Холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, уялдаа холбоог хангасан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.6. (6)</b></p>	<p>Батлагдсан</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсруулсан бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төслийн тоо;</li> </ul>	<p>Орон сууц хувьчлах тухай хуулийн зохицуулалт өнөөгийн байдалд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн зохицуулалт</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>

<p>Төрийн болон орон нутгийн өмчийн орон сууцны хувьчлалын талаарх бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан төслийн тоо;</li> <li>- Засгийн газрын шийдвэрийн дагуу орон сууц хувьчлах ажлыг зохион байгуулах;</li> <li>- Орон сууц хувьчлах товчоодын үйл ажиллагаанд хяналт тавих.</li> </ul>	<p>нийцэхгүй болсон, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай болсон.</p> <p>Орон сууцыг хувьчлах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, 2021 онд 183 айлд эрхийн бичиг олгосон.</p>	<p>боловсронгуй болсон байна;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн хэрэгжилтийг хангасан байна;</li> <li>- Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна;</li> <li>- Орон сууц хувьчлах товчоодын үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.</li> </ul>		
<p><b>Арга хэмжээ 1.7. (7)</b></p> <p>Орон нутгийн өмчийн эд хөрөнгөөс хувьчлах жагсаалтыг зөвшилцөх асуудлыг судлан шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зөвшилцөхөөр ирүүлсэн саналын тоо;</li> <li>- Зөвшилцөх асуудлаар гаргасан шийдвэрийн тоо;</li> <li>- Хяналтын тоо;</li> <li>- Нэгдсэн тайлан боловсруулсан эсэх.</li> </ul>	<p>Баянхонгор, Төв, Хөвсгөл, Орхон, Говь-Алтай зэрэг аймгийн хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцсөн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх асуудлаар хуульд нийцсэн шийдвэр гаргуулж, тухайн орон нутгийн удирдлагад хүргүүлсэн байна.</li> <li>- Нэгтгэн тайлагнасан байх.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.8. (8)</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа, хууль тогтоомж, журамд орсон өөрчлөлт, улсын үзлэг тооллого, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох судалгаа, хийж, дүгнэлт гаргах;</li> <li>- Мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангасан байх.</li> </ul>	<p>Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ажилтнуудад 2021 онд 2 удаа сургалт, зөвлөгөө өгч хамтран ажилласан.</p> <p>Дархан, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газарт, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Орон нутгийн өмчийн асуудлаар тухай бүр</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай судалгаа, мэдээлэлд үндэслэсэн байна;</li> <li>- Орон нутгийн удирдлага, орон нутгийн өмчийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, нэгдсэн удирдамж, арга зүйн дэмжлэгээр хангасан байна.</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг нэгдсэн нэг арга зүйгээр хангаж, удирдан зохион</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ХЭЗХ</p>

			зөвлөлдөх, мэргэжил, арга зүй, зөвлөгөөгөөр хангах ажлыг жилийн турш зохион байгуулав.	байгуулах ажлыг гүйцэтгэсэн байна.		
<b>Арга хэмжээ № 1.9. (9)</b> Төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаарх хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	Батлагдсан төсвийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангаж, тогтоосон хугацаанд тайлагнасан байх;</li> <li>- Хэрэгжилтэд хяналт тавьсан байх.</li> </ul>	Хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулан тайлагнасан.	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна;</li> <li>- Хяналт тавьсан байна;</li> <li>- Тогтоосон хугацаанд тайлагнасан байна;</li> <li>- Хэрэгжилт – 85% хувь.</li> </ul>	I-IV улирал	ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ХЭЗХ Захиргаа, удирдлагын хэлтэс (ЗУХ)
<b>Зорилт 2.</b> “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан хэрэгжүүлж, төрийн бүтээмжийг дэмжинэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан арга холбогдох хэрэгжилт, хувиар;</li> <li>- Зарим компанийг нээлттэй хувьцаат компани болгосон эсэх.</li> </ul>	- Холбогдох судалгаа хийсэн.	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан арга холбогдох арга хэмжээнийн хэрэгжилт – 80% хувь байна;</li> <li>- Зарим компанийг нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гарсан байна.</li> </ul>	I-IV улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 2.1. (10)</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, зохион байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа, тооцоо хийсэн байх;</li> <li>- Холбогдох санал, дүгнэлт боловсруулсан байх;</li> <li>- Засгийн газарт танилцуулсан байх.</li> </ul>	Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын засаглал, ашигт ажиллагаа, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал сайжирч, зарим компаниудыг нээлттэй хувьцаат компани болгох бэлтгэл ажлыг хангасан байна.</li> </ul>	I-IV улирал	ТӨУЗХ

<p><b>Арга хэмжээ 2.2. (11)</b></p> <p>Стратегийн ач холбогдол бүхий салбарт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор "Хөгжлийн сан корпораци" байгуулах асуудлыг судлах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа, тооцоолол хийх;</li> <li>- Санал, дүгнэлт, загвар боловсруулах;</li> <li>- Засгийн газарт танилцуулсан байх.</li> </ul>	<p>"Хөгжлийн сан корпораци", "Төрийн өмчийн корпораци байгуулах талаар санал боловсруулан Ерөнхий сайдад танилцуулсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Корпораци байгуулан бизнесийн шийдвэрийг "улс төрийн нөлөөлөл"-өөс ангид гаргадаг байх зарчимд шилжүүлэх арга хэмжээ авсан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 2.3. (12)</b></p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах үе шатны ажлыг эрчимжүүлэх</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байх;</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны зорилтот түвшинг хангасан байх.</li> </ul>	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний 2021 оны зорилтот түвшингийн хэрэгжилт дунджаар 80.0 хувь;</p> <p>МУИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх асуудалд тусгагсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүтээн байгуулалтын ажлуудыг хууль тогтоомжийн хүрээнд эрчимтэй зохион байгуулж, үр дүнг ахиулсан байна;</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2022 оны зорилтот түвшинг хангасан байна;</li> <li>- Бүтээн байгуулалтын ажлын явцад ахиц гарсан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 2.4. (13)</b></p> <p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний хөдөлгөөнд оролцох зохион байгуулалтын арга хэмжээ авч, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>- ТӨХЭ, ТӨБЗГ-ын оролцоог хангасан байна.</li> </ul>	<p>2021 онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хамрагдсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ гэх мэт аж ахуйн нэгжүүд тодорхой зорилт, хөтөлбөр батлуулсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шинээр тарьж, арчилж ургуулсан мод, талбайн хэмжээ нэмэгдсэн байна.</li> <li>- Төрийн өмчит хуулийн этгээд, ТӨБЗГ-ын оролцоог бүрэн хангах ажлыг зохион байгуулсан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ, ЗУХ</p>
<p><b>Арга хэмжээ № 2.5. (14)</b></p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-д нэгтгэх төрийн</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын зүгээс иргэдэд цахимаар үзүүлэх</li> </ul>	<p>"E-Mongolia"-д төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын зарим үйлчилгээ нэвтэрсэн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээний тоо нэмэгдсэн байна;</li> <li>- Үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>

өмчит үйлдвэрийн газар, компаниудын зарим үйлчилгээг нэмэгдүүлэх		үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байх; - Цахим үйлчилгээний тоо нэмэгдсэн байх.				
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 2.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хяналтыг сайжруулна.						
<b>Зорилт 3.</b> Компанийн засаглалыг сайжруулах олон улсын туршлага, удирдлага, менежментийг хэрэгжүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	- Шаардлагатай судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах; - Компанийн засаглалыг сайжруулах сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээ авсан байх; - Компанийн засаглалын үнэлгээ, хувиар.	- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. - Компанийн засаглалын үнэлгээг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд хийсэн. - Дундаж үнэлгээ – 64.8 хувь;	- Судалгаа хийж, санал, дүгнэлт гарган хэлэлцүүлсэн байна; - Компанийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлсэн байна; - Компанийн засаглалын дундаж үнэлгээ – 70 хувь болсон байна.	I-IV улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 3.1. (15)</b> Дэлхийн зарим улс орны төрийн өмчийн удирдлага, менежментийн сайн туршлагыг судлах, холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	- Судалсан байдал, улс орны тоогоор; - Туршлагыг нэвтрүүлсэн эсэх; - Хамтран ажилласан ТББ болон олон улсын байгууллага, тоогоор; - Компанийн засаглалын үнэлгээ, хувиар.	Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажилласан.	- Олон Улсын байгууллага, холбогдох ТББ-тай хамтран ажилласан байна; - Судалгаа, дүн шинжилгээ хийж, шийдэл гаргасан байна; - Оновчтой туршлагыг нэвтрүүлсэн байна; - Компанийн засаглалын үнэлгээ - 70 хувь.	II-III улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 3.2. (16)</b> Компанийн засаглалын чиглэлээр төрийн албан хаагчид, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	- Сургалтын хөтөлбөр боловсруулсан байх; - Хамрах хүрээг тодорхойлсон байх; - ОУ-ын байгууллагын дэмжлэгийг авсан байх; - Сургалтын хамрагдалт, тоогоор.	Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Азийн хөгжлийн банк, Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажилласан.	- ТӨБЗГ-ын албан хаагчид болон төрийн өмчит хуулийн этгээдүүдийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна; - Хамрагдалт – 100< албан хаагч.	II-III улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 3.3. (17)</b>	Батлагдсан	- Тусгайлсан хөтөлбөр гаргасан байх;	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	- Хувьцаа эзэмшигчийн эрхийг батлагдсан	IY улирал	ТӨУЗХ



<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөвлөлтийг сайжруулах, уялдаа холбоог хангах, аж ахуйн нэгжүүдийн хооронд туршлага солилцох, компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх чиглэлээр уулзалт, семинар, сургалт зохион байгуулах</p>	<p>төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамрах хүрээг тодорхойлох;</li> <li>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо;</li> <li>- Хамрагдалт, тоогоор;</li> <li>- Хөгжлийн урт, дунд хугацааны бизнес төлөвлөгөө баталсан компани, үйлдвэрийн газрын тоо.</li> </ul>	<p>арга хэмжээний төлөвлөгөөнд ТӨХЭ-ийн төлөвлөлтийг сайжруулах, бизнес төлөвлөгөөтэй болгох асуудал тусгагдсан.</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө, чиглэлийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	<p>удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байна;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжил, арга зүйн болон бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангаж ажилласан байна;</li> <li>- Зарим компани, үйлдвэрийн газар бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.</li> </ul>		
<p><b>Арга хэмжээ 3.4. (18)</b></p> <p>Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл зөвлөмжөөр хангах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөөлөн удирдлах зөвлөлд өгсөн удирдамж, чиглэлийн тоо;</li> <li>- Удирдамж, чиглэлийн хэрэгжилтийн хувь;</li> <li>- Хяналтын тоо.</li> </ul>	<p>Төрийн өмчит 51 компанийн 39 ТУЗ, төрийн өмчит 21 үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж, тухай бүр удирдамж, чиглэлээр хангаж, албан даалгавар хүргүүлэн хяналт тавин ажилласан байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдамж, чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцсон байна;</li> <li>- Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн байна;</li> <li>- Гүйцэтгэх удирдлагын баг, ТУЗ-ийн чадавхыг сайжруулах ажил зохион байгуулсан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 3.5. (19)</b></p> <p>Төрийн өмчит зарим компаниудын хувьцаа эзэмшигчдийн хуралд ТӨБЗГ-ын төлөөлөгчийг томилж, удирдамжийн дагуу оролцуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн төлөөлөгчийн удирдамжийг баталсан байх;</li> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТӨБЗГ-ыг төлөөлөх төрийн өмчийн төлөөлөгчийг томилох;</li> <li>- Төрийн өмчийн төлөөлөгчийн тоо.</li> </ul>	<p>Эрчим хүчний салбарын компаниуд болон “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн ХЭХ-д төлөөлөгч томилон оролцуулсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зарим компани, үйлдвэрийн газарт Төрийн өмчийн төлөөлөгчийг батлагдсан удирдамжийн дагуу ажиллуулсан байна;</li> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТӨБЗГ-ыг төлөөлөх төлөөлөгчийг томилон ажиллуулсан байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>

<p><b>Арга хэмжээ 3.6. (20)</b></p> <p>"Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2022" нээлттэй өдөрлөг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан эсэх;</li> <li>- Олон нийтийн хамрагдалтын тоо;</li> <li>- Үйл ажиллагаагаа сурталчлахаар оролцсон хуулийн этгээдийн тоо.</li> </ul>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулж ирсэн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, зарим үйлчилгээг иргэдэд үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</li> </ul>	<p>II улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Зорилт 4.</b></p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, менежмент, санхүүгийн удирдлагаар хангана.</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашигт ахиц гарсан байх;</li> <li>- Төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтийн хувь;</li> <li>- Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулсан хуулийн этгээдийн тоо.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилт 100%&lt;;</li> <li>- Улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашгийн орлого 209.3 тэрбум төгрөг;</li> <li>- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 50 хуулийн этгээдийг ТӨБЗГ-ын харьяалалд оруулж, хяналт тавих боломж бүрдүүлсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг дээшилсэн байна;</li> <li>- Төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлт - 100 хувь;</li> <li>- Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулсан хуулийн этгээдийн тоо – 50&lt;.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 4.1. (21)</b></p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо;</li> <li>- Хэрэгжилт, хувиар</li> <li>- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нээлттэй байдал.</li> </ul>	<p>Хэрэгжилт, дунджаар 80.0 хувь.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухайн үеийн тоо;</li> <li>- Хэрэгжилт - 90.0&lt; хувь;</li> <li>- Тайлагналт, мэдээллийн ил тод байдлыг хангасан байна.</li> </ul>	<p>I, IV улирал</p>	<p>ТӨУЗХ, ЗУХ</p>
<p><b>Арга хэмжээ 4.2. (22)</b></p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн</p>	<p>Батлагдсан</p>	<p>Зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө</p>	<p>45 хуулийн этгээдийн төлөвлөгөөг хянан ТӨБЗГ-ын хуралдаанд</p>	<p>- 2022 оны тодотгол – тухайн бүр.</p>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨУЗХ</p>

<p>оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянах, батлуулах</p>	<p>төсвийн хүрээнд</p>	<p>батлуулсан хуулийн этгээдийн тоо:  - 2022 оны тодотгол хийсэн хуулийн этгээд;  - 2023 оны төлөвлөгөө батлуулсан хуулийн этгээд.</p>	<p>танилцуулан шийдвэрлүүлсэн.  -</p>	<p>- 2023 оны төлөвлөгөө батлуулах хуулийн этгээд - 73.</p>		
<p><b>Арга хэмжээ 4.3. (23)</b>  Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэх удирдлагын контрактыг дүгнэх, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>- Холбогдох биелэлтийг дүгнэсэн байх;  - Гэрээ сунгах эсэх асуудлыг ТӨБЗГ болон холбогдох ХЭХ-аар шийдвэрлүүлсэн байх;  - Холбогдох хууль, журмын нийцлийг хангасан байх.</p>	<p>2021 онд 45 хуулийн этгээдийн 2020 оны зорилтот түвшин, захирлын контрактын биелэлтийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн:  - 21 ТӨҮГ;  - 24 ТӨХК.</p>	<p>- ТӨБЗГ-ын төлөөлөл оролцдог нийт 73 хуулийн этгээдийн 2021 оны үр дүнг хэлэлцэн шийдвэрлэсэн байна;  - 2022 оны гэрээг байгуулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>II улирал</p>	<p>ТӨҮЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 4.4. (24)</b>  Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоож, улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>- Төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоосон байх;  - Төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөөнд санхүүгийн бүртгэлийн хяналт тавьж, тооцоо нийлсэн байх;  - Ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтийн хувь.</p>	<p>- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилт 100%&lt;;  - Улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашгийн орлого 209.3 тэрбум төгрөг;  - Үүнээс: Ирээдүйн өв санд төвлөрүүлсэн орлого 155.0 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 54.3 тэрбум төгрөг.</p>	<p>- Төрийн өмчит хуулийн этгээдийн ногдол ашиг төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоосон шийдвэр гарсан байна;  - Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүрэг – нийт 448.43 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ;  - Үүнээс: Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлого – 404.53 тэрбум төгрөг;  - Төрийн өмчийн хувьцааны ногдол ашиг – 43.9 тэрбум төгрөг;</p>	<p>III-IV улирал</p>	<p>ТӨҮЗХ ЗУХ</p>

				- Орлого төвлөрүүлэлтийн ажилд гүйцэтгэлийн болон санхүүгийн хяналт тавьж, тооцоо нийлсэн байна.		
<b>Арга хэмжээ 4.5. (25)</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэгтгэл болон хууль эрх зүйн товхимол, гарын авлага гаргах	Батлагдсан төсвийн хүрээнд	- Боловсруулалт, бэлтгэл ажил хууль журамд нийцсэн байх; - Хэвлэлийн компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх; - Товхимол, гарын авлага хэвлэгдсэн эсэх.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэсэн.	- Товхимолд орох материалыг нэгтгэж, эхийг бэлтгэсэн байна; - Хэвлэлийн компанитай гэрээ байгуулан хэвлүүлсэн байна; - Товхимол, гарын авлагыг холбогдох алба хаагчид, хэрэглэгчид түгээж, сурталчилсан байна.	II улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 4.6. (26)</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023-2025 оны зорилтын саналыг хянан нэгтгэж, санал дүгнэлт боловсруулах	Батлагдсан төсвийн хүрээнд	- Зорилтын саналыг хүлээн авах; - Саналыг хянан нэгтгэх; - Нэгдсэн санал, дүгнэлт боловсруулах; - Саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байх; - Нэгтгэлд хамрагдсан байгууллагын тоо.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021-2023 оны зорилтын саналыг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн.	- Зорилтын саналыг нэгтгэсэн байна; - Нэгдсэн санал дүгнэлт, танилцуулга бэлтгэсэн байна; - Сангийн яаманд хүргүүлсэн байна. - Саналд хамрагдсан байх байгууллагын тоо – 49<.	II улирал	ТӨУЗХ
<b>Арга хэмжээ 4.7. (27)</b> Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих	Батлагдсан төсвийн хүрээнд	- Холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд тайлан, төлөвлөгөөг ирүүлсэн болон боловсруулсан эсэх; - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахим системд хянан нэгтгэж, илгээсэн эсэх; - Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 50 хуулийн этгээдийн бүртгэл мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ТӨБЗГ-ын харьяалалд оруулсан.	- 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг хүлээн авч хянан баталж, Сангийн яаманд илгээсэн байна; - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн нэгтгэлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ЗГХЭГ-т хүргүүлсэн байна - Худалдан авах ажиллагааг цахим	I-IV улирал	ТӨУЗХ

		байгуулсан хуулийн этгээдийн тоо.		системээр зохион байгуулсан хуулийн этгээдийн тоо – 50<		
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 3.</b> Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.						
<b>Зорилт 5.</b> Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байх;</li> <li>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтэд дүн шинжилгээ хийж, авах арга хэмжээний үр нөлөөг сайжруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үзлэг, тооллогыг 2022 онд зохион байгуулах асуудлаар Засгийн газрын шийдвэр гарсан;</li> <li>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны биелэлтийн улсын дундаж үнэлгээ 93.03 хувь (2021 онд дүгнэсэн).</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулан, цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гаргуулсан байна;</li> <li>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2021 оны биелэлтийг дүгнэж, хөрөнгийн ашиглалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.</li> </ul>	I-IV улирал	ТӨБАХ
<b>Арга хэмжээ 5.1. (28)</b> Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын үзлэг, тооллого зохион байгуулагдсан байх;</li> <li>- Дүн, нэгтгэлийг боловсруулж, Засгийн газарт танилцуулсан байх;</li> <li>- Үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон холбогдох шийдвэр гаргуулсан байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 2016 онд улсын үзлэг тооллогыг зохион байгуулж байсан.</li> <li>- Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолоор улсын үзлэг, тооллогыг 2022 онд зохион байгуулах шийдвэр гарсан.</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлтгэл ажил, зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна;</li> <li>- Улсын үзлэг, тооллогыг улс орон даяар явуулж, 21 аймаг, нийслэлийн өмчийн тооллого, дүнг удирдан зохион байгуулсан байна;</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнг нэгтгэх, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГХЭГ-т тайлагнасан байна;</li> <li>- Үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</li> </ul>	I-IV улирал	ТӨБАХ

<p><b>Арга хэмжээ 5.2. (29)</b></p> <p>Аймаг, нийслэл, орон нутаг дахь төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2021 оны биелэлтийг дүгнэж, 2022 оны гэрээг сунгах ажлыг зохион байгуулах</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийг дүгнэх, гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулсан байх;</li> <li>- Гэрээний тоо, хэрэгжилтийн улсын дундаж хувь;</li> <li>- Гэрээний хэрэгжилтийн дүнд дүгнэлт хийж, авах арга хэмжээг тодорхойлсон байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 2021 онд төрийн өмчит 985 хуулийн этгээдтэй гэрээг шинэчлэн байгуулж, дүгнэсэн бөгөөд гэрээний биелэлтийн улсын дундаж үнэлгээ 93.03 хувь;</li> <li>- Гэрээний дүнгийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, холбогдох зөвлөмжийг төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэсэн байна;</li> <li>- Гэрээний хэрэгжилтийн улсын дундаж 91.9% хувь байна (4 жилийн дундаж үнэлгээ);</li> <li>- Төрийн өмчит 985 хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г сунгасан байна;</li> <li>- Дүн, дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨБАХ</p>
<p><b>Зорилт 6.</b></p> <p>Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн төсвийн орлогыг бүрдүүлж, зардлыг бууруулна.</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өөрийн өмчийн түрээс орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, тэрбум төгрөгөөр;</li> <li>- Төрийн өмчийн ашиглалтын зардлыг бууруулах арга хэмжээ авсан байх.</li> </ul>	<p>Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээний дүнд 2021 онд улсын төсөвт 2.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.</p>	<p><b>Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалттай холбоотой 1.8 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өөрийн өмчийн түрээс орлого 1.6 тэрбум төгрөг;</li> <li>- Хөдлөх хөрөнгийн дуудлага худалдаанаас 200.0 сая төгрөг.</li> </ul>	<p>I-IV улирал</p>	<p>ТӨБАХ</p>
